



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2023 оны 08 сарын 03 өдөр

Дугаар 97

Хэрлэн сум

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хүний нөөц, дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтний сул орон тоонд томилуулахаар нэр дэвшүүлэх тухай


Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 5.7, 3.5, 3.5.4 дэх заалт, 2023 оны 25 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 12.1, 12.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн албаны тусгай шалгалтад /61/ оноо авч, тэнцсэн Эрдэнэхишигийн Баярмааг аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хүний нөөц, дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтний сул орон тоонд томилуулахаар нэр дэвшүүлсүгэй.

2. Нэр дэвшигч Э.Баярмааг тухайн албан тушаалд томилсон шийдвэрийг 30 хоногийн дотор гаргаж, албан бичгээр ирүүлэх шаардлагатайг аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга (Э.Хонгорзул)-д зөвлөсүгэй.

3. Энэхүү тогтоолыг аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт хүргүүлж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ш.Эрдэнэжаргал)-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР